



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 405

Баянхутаг

**Албан тушаалын тодорхойлолт
батлах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, "Төрийн албаны тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 553 дугаар тогтоолын /албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам/ 2019 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Соёлын төвийн номын санчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, дуу хөгжмийн багшийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Орон нутаг судлах танхимийн ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, бүжгийн багшийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, үйлчлэх ажилтны албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Албан тушаалын тодорхойлолтонд заагдсан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллахыг албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Соёлын төвийн даргын 2022 оны 09 дүгээр сарын 30- ны өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХХЭРЛЭН